



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/226

Булган сум

**Нийлүүлэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Ахмадын амралт, сувиллын эмчилгээ сувилгааны тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчээр шалгарсан “Санаа мед трейд” ХХК-тай 23,990,000 (хорин гурван сая есөн зуун ерэн мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т олгосугай.


2. Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авах, данс бүртгэлд тусгахыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Н.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, техникийн үзүүлэлтийн дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Санаа мед трейд” ХХК-ийн гүйцэтгэх захирал (А.Батцэнгэл)-д даалгасугай.

4. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус төсөл арга хэмжээний санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010308

Аймгийн Засаг даргын 2024 оны  
04 дүгээр сарын 09-ний өдрийн А/226 дугаар  
захирамжийн хавсралт

Д/д	Нөхцөл шаардлага	Тайлбар	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Бараа нийлүүлсний дараах чанарын болон баталгаат засварын хугацаа	1 жил	Н.Батжаргал
2	Алданги	Хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
3	Бараа нийлүүлэх хугацаа	Гэрээнд зааснаар	М.Батчимэг Н.Батжаргал